# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 20 өдөр Дугаар 100 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 6.4.4, 6.4.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 9,000,000.00 (есөн сая) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, сэлбэгээр худалдахыг зөвшөөрсүгэй.

2.Ховд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Бямбажавт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор акталж, данснаас хасах, худалдах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Сэлбэгээр худалдсанаас олох орлогыг зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.4.Автомашиныг худалдсаны дараа авто тээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

132000299

4-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны ...02..... дугаар сарын ..20......-ны өдрийн
...100..... дугаар тогтоолын хавсралт

ХОВД АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Хөрөнгийн нэр, марк, улсын дугаар | Арлын дугаар | Ашиглалтанд орсон огноо | Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл | Акталж, сэлбэгээр худалдах доод үнэ |
|---|---|---|---|---|---|
| | | | | (төгрөг) | |
| 1 | Тээврийн хэрэгсэл (Тоёота карина маркийн 18-51 ХОҮ улсын дугаартай) | АТ2120098676 | 2012.01.01 | 9,000,000 | 250,000.00 |
| | Нийт дүн | | | 9,000,000.00 (есөн сая) | 250,000.00 (хоёр зуун тавин мянга) |